
Airplus MCD-650

CDMA 1xEVDO USB Модем

Гарын авлага



Airplus MCD-650 CDMA 1xEV-DO USB Модем
Гарын авлага

Airplus MCD-650 модемны мэдээлэл

Airplus MCD-650 USB модем нь CDMA 1xEVDO технологи дээр суурилан агаарын замаар 2.4Mbps буюу өндөр хурдаар интернэтэд холбох авсаархан төхөөрөмж юм.

Ерөнхий үзүүлэлтүүд

- CDMA 1xEVDO сүлжээнд 2,4Mbps хурдаар интернэтэд холбогдох болно.
- Өгөгдлийн хэмжээ зэрэг мэдээллийг шалгах боломжтой.
- windows 98, ME, 2000, XP болон Vista бүх үйлдлийн систем дээр ажиллах боломжтой
- CDMA 450MHz давтамж
- CDMA 2000 1xEV-DO технологитой
- 2 давхар мессеж илгээх боломжтой
- Яриа хийх боломжтой
- Хэмжээ: 86 x 39 x10.мм
- Жин: 30гр

Системн шаардлага

- Intel Pentium процессор
- 30MB сул хэмжээтэй байх
- CD ROM драйвертэй байх

Хайрцаганд

Airplus MCD-650 CDMA 1xEV-DO USB модем, драйвер CD(Гарын авлагатай)

Хэрхэн модем суулгах бэ.

Airplus MCD-650 модемыг оролтонд залгана.

Дохионы гэрэл асах болно.

* Анхааруулга : Хэрвээ модемыг буруу оролтод залгавал модем эвдрэх аюултай.

Зөвлөмж

- Өндөр температурт болон хэт чийгтэй газар хадгалаж хэрэглэхгүй байх. Усанд унагах, бороонд норгох зэрэг нь механик гэмтэлд хүргэж болзошгүй юм.
- Бүтээгдэхүүнийг өөрсдөө задалж угсрахыг хориглоно.
- Унагах доргиох цохиж болохгүй. Энэ нь аюулгүйн ажиллагаанд гэмтэл учруулна.
- Дэлбэрэх тэсрэх зүйлийн хажууд хэрэглэхгүй байх.
- Ямар нэгэн илүү антен задгаж болохгүй.
- Оролтод зөөлөн зөв шургуулах хэрэгтэй.

* Жич : Үйлчилгээний хурд нь үйлчилгээ үзүүлэгч оператороос хамаарна.



Гарчиг

Airplus MCD-650 танилцуулга	2
1. Модемыг суулгах	Error! Bookmark not defined.
1.1 Программыг суулгах.....	7
1.2 Драйвер таниулах (Windows 98/ME)	11
1.3 Драйвер таниулах (Windows 2000)	12
1.4 Драйвер таниулах (Windows XP/Vista).....	13
2. Программыг устгах	Error! Bookmark not defined.
2.1 Программыг устгах.....	16
2.2 Драйверыг устгах.....	18
3. Программыг ашиглах	Error! Bookmark not defined.
3.1 Ажиллуулж эхлэх	19
3.2 Үндсэн дэлгэц	20
3.3 Шинэ мессеж бичих (New message).....	20
3.4 Мессежний дэлгэц (Message).....	20
3.5 Дуудлагын түүх (Call History)	21
3.6 Утасны жагсаалт (Phonebook).....	23
3.7 Тохиргоо (Phone settings)	23
4. Дуудлага.....	Error! Bookmark not defined.
4.1 Дуудлага хийх.....	25
4.2 Дуудлага хүлээн авах.....	25
4.3 Дуудлагын түүх (Call history)	26
4.4 Дуудлагын түүх устгах.....	26
4.5 UIM картанд дугаар хадгалах	28
5. Мессеж.....	Error! Bookmark not defined.
5.1 Шинэ мессеж бичих	29
5.2 Мессеж хүлээн авах	30
5.3 Илгээсэн мессеж	31
5.4 Хадгалсан мессеж	31
5.5 Мессеж устгах	32
5.6 UIM картанд дугаар хадгалах	32
6. Утасны жагсаалт (Phonebook)	33
6.1 Шинэ дугаар нэмэх.....	33
6.2 Дугаар өөрчлөх.....	33
6.3 Хадгалагдсан дугаараас устгах.....	35
6.4 Сонгосон дугаар руу дуудлага хийх	35
6.5 Сонгосон дугаар руу мессеж бичих.....	36
6.6 UIM картнаас дугаар хайх	36
7. Утасны тохиргоо	Error! Bookmark not defined.
7.1 Хонх/дууны түвшин	37
7.2 Дуудлагын хугацаа.....	38
7.3 Интернэтэд холбогдох тохиргоо	36


7.4 Нэмэлт үйлчилгээ.....	37
7.5 Хамгаалалт	38
7.6 Өгөгдлийн хэрэглэсэн хэмжээ.....	39
7.7 Интернет(TCP/IP)	40
7.8 Мэдээлэл.....	41
8. Интернет	Error! Bookmark not defined.
8.1 Интернетэд холбогдох.....	46
8.2 Интернет салгах.....	47
9. Үзүүлэлтүүд.....	Error! Bookmark not defined.

1. Модемыг суулгах


Airplus MCD-650 CDMA 1xEV-DO USB модемыг ашиглахын тулд та төхөөрөмжийн программыг суулгах хэрэгтэй.

1.1 Программыг суулгах


- (1) Программыг ажиллуулж эхлэнэ.
- (2) 'Next' гэснийг сонгож дарна.




- (3) 'Next' гэснийг дарсны дараа программ суух байршлыг тохиуулна.




(4) 'Install' гэсэн товчлуурыг дарна.



(5) Программ сууж, суух явц нь харагдах болно.



(6) Таны компьютерыг "Restart" хийх үү гэсэн арултад "Yes" сонголтыг хийх хэрэгтэй. Интэснээр таны компьютер дахин асах болно.



(7) таны компьютер ассаны дараа "Airplus MCD-650.exe" зүйл нэмэгдсэн байх болно.




Airplus.ico

1.2 Драйвер таниулах (Windows 98/ME)

- (1) Компьютер унтарч ассаны дараа Airplus MCD-650 USB модемыг холбох хэрэгтэй.
- (2) 'Airplus MCD-650 CDMA 1xEV-DO Wireless Modem' төхөөрөмжийг таны компьютер автоматаар таних болно.

(3) Драйвер таних ажил ингэснээр дуусах болно. Хэрэв та бүрэн танигдсан эсэхийг шалгахыг хүсвэл системийн "Device manager" дотор орж модем гэсэн хэсэгт 'Airplus MCD-650 CDMA 1X Wireless Modem Port' ба 'Airplus MCD-650 CDMA Status Port' байгаа эсэхийг шалгана уу.




1.3 Драйвер таниулах (Windows 2000)

- (1) Компьютер унтарч ассаны дараа Airplus MCD-650 USB модемыг холбох хэрэгтэй.
- (2) 'Airplus MCD-650 CDMA 1xEV-DO Wireless Modem' төхөөрөмжийг таны компьютер автоматаар таних болно.
- (3) Доорх асуулт цонх гарч ирэхэд 'Continue anyway' гэснийг сонгоно.



- (4) Драйвер таних ажил ингэснээр дуусах болно. Хэрэв та бүрэн танигдсан эсэхийг шалгахыг хүсвэл системийн "Device manager" дотор орж модем гэсэн хэсэгт 'Airplus MCD-650 CDMA 1X Wireless Modem Port' ба 'Airplus MCD-650 CDMA Status Port' байгаа эсэхийг шалгана уу.




1.4 Драйвер таниулах (Windows XP/Vista)

- (1) Компьютер унтарч ассаны дараа Airplus MCD-650 USB модемыг холбох хэрэгтэй.
- (2) 'Airplus MCD-650 CDMA 1xEV-DO Wireless Modem' төхөөрөмжийг таны компьютер автоматаар таних болно. Доорх цонх гарч ирэхэд "Next" гэснийг сонгоно.




- (3) "Next" гэснийг сонгоход драйвер таних ажил автоматаар дуусах болно.



(4) Доорх асуулт цонх гарч ирэхэд 'Continue anyway' гэснийг сонгоно.




(5) Драйвер таних ажил ингэснээр дуусах болно. Хэрэв та бүрэн танигдсан эсэхийг шалгахыг хүсвэл системийн "Device manager" дотор орж модем гэсэн хэсэгт 'Airplus MCD-650 CDMA 1X Wireless Modem Port' ба 'Airplus MCD-650 CDMA Status Port' байгаа эсэхийг шалгана уу.




2. Программыг устгах


2.1 Программыг устгах

- (1) Өөрийн компьютерын Control Panel дотор орж "Add or Remove Programs" цэс рүү орж Airplus MCD-650 модемны программыг сонгож "Remove" гэсэн товчыг дарна.




- (2) Доорх тохиргооны цонх гарч ирэхэд 'Remove' гэснийг сонгож 'Next' гэсэн товчлуурыг дарна.






(3) Программ устгагдах болно.




2.2 Драйверыг устгах

(1) "Device manager" дотор модем гэсэн хэсэгт "Airplus MCD-650 CDMA 1xEV-DO Wireless Modem" –ийг сонгоно.



(2) "Airplus MCD-650 CDMA 1xEV-DO Wireless Modem" дээр хулганы баруун товчлуурыг дарж "Uninstall" гэснийг сонгоно.



3. Программыг ашиглах

3.1 Ажиллуулж эхлэх

(1) Шинээр үүссэн доорх дүрсийг ажиллуулна.



Airplus
MCD-650

(2) Доорх цонх гарч ирэн программыг автоматаар ажиллуулж программын үндсэн дэлгэцийг гаргана.



3.2 Үндсэн дэлгэц

Үндсэн дэлгэц нь доорх байдалтай байна. Үндсэн дэлгэцийн цэнхэр хэсэг болох үзүүлэлтийн дэлгэцний дээд хэсэгт сүлжээний байдал, ярианы дууны түвшин, шинэ ирсэн мессеж гэх зэрэг харагдана. Дээд төв хэсэгт цаг гарна. Үндсэн цэсэнд Интерэнэт, Утас, Шинэ мессеж, Мессеж, Утасны жагсаалт, Дуудлагын түүх, Тохиргоо хэрэглэгчид зэрэг цэс байрлана.

Дуудлага хийх бол баруун талын хэсгээс дугаараа сонгож оруулаад "Send" товчлуурыг дарна.




3.3 Шинэ мессеж бичих (New message)

Үндсэн цэснээс шинэ мессеж бичих (New message) цэсийг сонгож дарснаар мессеж бичих цэсэнд орно. Уг цэсэнд залгах хэсгийн орон "delete all" буюу бүгдийг устгах, "delete" буюу ширхэг тэмдэгтээр устгах, "save" буюу хадгалах "send" буюу илгээх сонголтууд байрлана. Цэнхэр хэсэгт хулганаар дарснаар та мессеж бичих боломжтой болно. Мессеж-ээ та дараах сонголтоор илгээнэ: энгийн (NRM), Яаралтай (URG), онцгой (EMG)



Мессеж илгээхдээ утасны жагсаалтнаас сонгож илгээх бол томруулдаг шилний зурагтай жижигхэн дүрсийг дарж дугаарын жагсаалтыг гаргаж, илгээх дугааруудаа сонгоно.



3.4 Мессежний дэлгэц

Үндсэн цэснээс мессеж (message) цэсийг сонгож дарснаар мессеж шалгах, унших цэсэнд орно. Уг цэсэнд залгах хэсгийн орон "delete all" буюу бүгдийг устгах, "delete" буюу ширхэг тэмдэгтээр устгах, "FWD" буюу шилжүүлэх, "Reply" буюу хариу илгээх сонголтууд байрлана. Эдгээр сонголтын дээд хэсэгт байрлах хэсгийн эхний сонголтоос Ирсэн/Илгээсэн/Хадгалсан(Inbox/Outbox/Saved) зэрэг сонголтоос сонгон мессеж унших болно. Мөн хажуу талынх нь товчлуураар дуудлага хийж "Dial", мессеж бичих(SMS) болно.



3.5 Дуудлагын түүх (Call history)

Энэхүү цэсэнд SMS товчлуур, Del all, Del, FWD болон хариу бичих товчлуурууд байрлана. Дуудлага хийсэн дуудлагууд руу мессеж бичих, дахин дуудлага хийх зэрэг үйлдлүүдийг хийх боломжтой.




3.6 Утасны жагсаалт (Phonebook)

Үндсэн цэсэн дунд Утасны жагсаалт цэс байрлана. Энэ цэсэнд Add буюу шинээр нэмэх, Edit буюу өөрчлөх, Find буюу хайх, Del буюу устгах товчлуурууд байрлана. UIM карт дахь дугааруудыг харах болно.



3.7 Тохиргоо (Phone Setting)

Тохиргоо цэсэнд модемны бүх тохиргоог хийх болно.



4. Дуудлага

4.1 Дуудлага хийх

Утаснаас дуудлага хийхтэй яг адилхан юм.

- (1) Дугаар оруулах үндсэн товчлууруудаас залгах дугаараа шууд оруулж залгах товчлуурыг дарж дуудлага хийнэ.
- (2) Дугаар оруулалгүй залгах товчлуурыг дарахад сүүлд хэрэглэсэн дугаарууд дэлгэцэнд гарч ирнэ. Залгах товчлуурыг дахин дарснаар тухайн дугаар руу дуудлага хийх болно.
- (3) Дугаар оруулалгүй залгах товчлуурыг удаан дарахад сүүлд залгасан дугаарууд дэлгэцэнд гарч ирнэ. Залгах товчлуурыг дахин удаан дарснаар тухайн дугаар руу дуудлага хийх болно.



4.2 Дуудлага хүлээн авах

- (1) Гаднаас дуудлага ирэхэд дэлгэцэнд нэр, дугаар нь гарах (хэрэв UIM картанд хадгалагдсан дугаар бол) ба хөдөлгөөнт дүрс болон хонх дугарах болно.
- (2) Залгах товчлуурыг дарснаар дуудлагыг авах болно. Хэрэв дуусгах буюу "End" товчлуурыг дарснаар дуудлагыг цуцлах болно.




4.3 Дуудлагын түүх

(1) Та өөрийн харахыг хүссэн дуудлагын төрлийг сонгохдоо доош буудаг цэснээс сонгоно. (Total call буюу нийт дуудлага, Incoming call буюу Ирсэн дуудлага, Outgoing буюу гарсан дуудлага, Missed call буюу аваагүй дуудлага гэсэн төрөлтэй)

(2) Дуудлагын түүхийн жагсаалтад байгаа дугааруудаас сонгон "Dial" товчлуурыг дарж шууд холбогдож болно.

(3) Мөн дуудлагын түүхийн жагсаалтад байгаа дугааруудаас сонгон SMS товчлуурыг дарж шууд мессеж бичиж болно.




4.4 Дуудлагын түүх устгах


Хүсвэл дуудлагын жагсаалтнаас арилгаж болно. Ингэхийн тулд арилгахыг хүссэн дугаараа сонгон "Del" товчлуурыг дарна. Эсвэл арилгахыг хүссэн дугаар дээрээ хулганы баруун товчыг дарж "Delete" гэснийг сонгож болно.



Бүх дуудлагын түүхийг устгахыг хүсвэл Del All гэсэн товчыг дарна. Ингэхэд таниас батлах асуулт асуух болно. Та "Yes" гэж сонгосноор бүх түүх устгах болно.



4.5 Дугаарыг утасны жагсаалтад хадгалах



Хэрэв дугаарыг утасны жагсаалтад хадгалахыг хүсвэл сонгосон дугаар дээрээ хулганы баруун товчыг дарахад гарч ирэх цэснээс "Add number" гэснийг сонгоно. Ингэхэд шинээр утасны жагсаалтад бүртгэх цонх гарч ирэх болно.


5. Мессеж

5.1 Шинэ мессеж бичих

(1) Мессеж бичихийг хүсвэл үндсэн цэсэн дундаас шинэ мессеж бичих гэснийг сонгож дарна.



(2) Мессеж илгээхдээ утасны жагсаалтнаас сонгож илгээх бол томруулдаг шилний зурагтай жижигхэн дүрсийг дарж дугаарын жагсаалтыг гаргаж, илгээх дугааруудаа сонгоно.



5.2 Мессеж хүлээн авах

(1) Шинэ мессеэ ирэхэд шинэ мессеж ирсэнийг анхааруулсан хонх дугарч, шинэ цонх гарч ирнэ.




(2) "Yes" гэсэн сонголтыг хийхэд шинэ мессеж дэлгэцэнд гарч ирнэ, харин "No" гэсэн цэсийг сонгоход анхааруулга цонх хаагдах болно.

5.3 Илгээсэн болон хүлээн авсан мессеж


(1) Мессеж илгээхэд Outbox цэсэнд, Мессеж хүлээн авахад Inbox цэсэнд автоматаар хадгалагдах болно.

(2) Та энэхүү цэснээс хариу мессеж бичих дуудлага хийх, устгах зэрэг бусад үйлдлийг хийх боломжтой юм.




5.4 Хадгалсан мессеж (Saved)

Уг цэсэнд амжилтгүй илгээгдсэн болон сануулсан мессежнүүд нь хадгалагдана.



5.5 Мессеж устгах

- (1) Хэрвээ мессежийг нэг нэгээр нь устгахыг хүсвэл "Delete" товчлуурыг дарна.
- (2) Бүх мессежийг устгахыг хүсвэл "Delete all" товчлуурыг дарна. Баталгаа авч доорх асуулт гарах болно.



5.6 UIM картанд дугаар хадгалах


Та хүлээн авсан мессежийнхээ дугаарыг утасны жагсаалтад бүртгэх боломжтой юм. Мессежийн жагсаалтнаас хадгалахыг хүссэн дээрээ хулганы баруун товчыг дарж "Add number" гэснийг сонгоно. Хэрвээ дугаар өмнө нь бүртгэгдсэн байсан бол өөрчлөх цэс рүү автоматаар орох болно.



6. Утасны жагсаалт (Phone Book)


6.1 Шинэ дугаар нэмэх

(1) Хэрэв шинэ дугаар утасны жагсаалтад нэмэхийг хүсвэл баруун товчыг дарж "Add button" товчлуурыг сонгоно. Ингэхэд шинэ хэрэглэгчийн дугаар бүртгэх шинэ цонх гарах болно. Мэдээллээ оруулаад ОК товчлуурыг дарснаар Утасны жагсаалтад бүртгэгдэх болно.




6.2 Дугаар өөрчлөх

(1) Утасны жагсаалт дахь дугаарт өөрчлөлт оруулахыг хүсвэл жагсаалт дундаас өөрчлөл оруулах дугаараа сонгон хулганы баруун товчыг дарж өөрчлөх цэсийг сонгосоход өөрчлөлт оруулах шинэ цонх гарч ирнэ. Өөрчлөлтийг оруулаад ОК дарна.



6.3 Хадгалсан дугараас устгах

- (1) Хэрвээ дугаарын жагсаалтнаас сонгож устгахыг хүсвэл "Delete" товчлуурыг дарна.
- (2) Бүх дугаарыг устгахыг хүсвэл "Delete all" товчлуурыг дарна. Баталгаа авч доорх асуулт гарах болно.



6.4 Сонгосон дугаар руу дуудлага хийх

- (1) Утасны жагсаалтнаас залгах дугаараас онгон хулганы баруун товчыг дарж гар ирэх цэснээс Dialing гэснийг сонгоц дарснаар дуудлага хийх болно.



6.5 Сонгосон дугаар руу мессеж бичих

(1) Утасны жагсаалт дундаас хүссэн дугаар руугаа мессеж бичиж болно. Ингэхийн тулд мессеж явуулах дугаараа согон хулганы баруун товчыг дарж Send SMS гэснийг сонгож дарахад мессеж бичих шинэ цонх гарч ирнэ.



6.6 UIM картнаас хайх

(1) Утасны жагсаалтын дугаараас хайлт хийхийг хүсвэл доор байрлах Find товчлуурыг дарах хэрэгтэй. Дарсны дараа хайлт хийх шинэ цонх гарч ирэх болно. Дугаар эсвэл нэрээ оруулаад ОК товчлуурыг дарна.



7. Утасны тохиргоо

Утасны тохиргоо

Дууны бусад бохиргоонуудыг энэхүү цэснээс хийх болно.

7.1 Хонх/дууны түвшин

(1) Хонх


Энэ цэсэнд та хонхны төрлөөс сонгох, мессежний хонхыг тохируулах болно. Таны тохируулсан хонх нь дуудлага ирэх, мессеж ирэхэд дугарах болно. Та хонхыг wav, mp3, midi файлаар тохируулах боломжтой.

(2) Ярианы дууны түвшин

Энэ цэсэнд дууны түвшингийн тохиргоог хийх болно. Тохиргоог хийсний дараа Apply товчлуурыг дарах хэрэгтэй.


(3) Бусад дохио

Энд товчлуур, холбогдоход, тасрахад гарах дууг тохируулах болно. Тохиргоог хийсний дараа Apply товчлуурыг дарах хэрэгтэй.




7.2 Дуудлагын хугацаа

Өөрийн хийсэн дуудлагын хугацааг харах болно. Ингэж харахдаа гадагш гарсан буюу Sent call, хүлээн авсан буюу Received call, сүүлийн дуудлага буюу Last call, нийт дуудлагын нийлбэр хугацаа буюу Total call гэсэн ангилалтай.



7.3 Интернэтэд холбогдох тохиргоо

Тохиргоо цэснээс Connection буюу холболтын тохиргоог хийнэ. Энэхүү цэсэнд орж интернэтэд холбогдох хэрэглэгчийн нэр, нууц кодоо оруулна. Тохиргоог хийсний дагаа Apply товчлуурыг дарх шаардлагатай.



The image shows a 'Setting' dialog box with a blue title bar and a close button. It has a tabbed interface with the following tabs: Security, Information, Internet (TCP/IP), Data usage, Sound/Volume, Call usage, Connection, and Service. The 'Connection' tab is selected. Inside the dialog, there are two radio buttons: 'Default' (selected) and 'Custom'. Below these are three text input fields: 'ID : CDMA', 'Password : ****', and 'Number : #777'. An 'Init' button is located below the 'Number' field. At the bottom of the dialog are three buttons: 'OK', 'Cancel', and 'Apply'.

7.4 Нэмэлт үйлчилгээ

Дуудлага шилжүүлэх, хүлээлгэх болон автомат бүсийн кодын тохиргоог хийх боломжтой.

(1) Дуудлага шилжүүлэх

Таны дугаарт ирсэн дуудлагыг тодорхой нөхцөл заан, шилжүүлэхээр сонгосон дугаарт тань дуудлага шилжүүлэх тохиргоо юм.


- CFB (Завгүй үед дуудлага шилжүүлэх) – Таны утас завгүй байх нөхцөлд ирж буй дуудлагыг шилжүүлнэ.
- CFNA (Хариу өгөөгү үед дуудлага шилжүүлэх) – Таньд ирсэн дуудлагад та хариу өгөхгүй байх нөхцөлд дуудлагыг шилжүүлэх үйлчилгээ.
- CFU (Шууд дуудлага шилжүүлэх) – Таны утас унтарсан, асаалттай, завгүй зэрэг бусад ямар ч нөхцөлийг үл хамааран таньд ирэх бүх дуудлагыг таны сонгосон дугаар уруу шилжүүлнэ.

(2) Дуудлага хүлээлгэх

Дуудлага хийгдэж байх үед орж ирсэн өөр нэг дуудлагыг давхар авч, өмнөх дуудлагыг түр хүлээлгэх үйлчилгээ.

(3) Автомат бүсийн код

Бусад улс орон, орон нутаг бүс хооронд ярихад ашиглагддаг кодыг автоматаар хийгдэх тохиргоог энэхүү цэсээр хийх болно.




7.5 Хамгаалалт

(1) ПИН түгжээ/ ПИН код солих

ПИН код таны UIM картыг түгжих эсвэл түгжээгүй болгох тохиргоо юм. Хэрвээ ПИН кодыг идэвхжүүлсэн нөхцөлд таны төхөөрөмжийг асах бүрд ПИН код нэхэх болно. Хэрвээ ПИН кодоо олон удаа буруу хийвэл таны UIM карт цоожлондох болно. Ингэсэн тохиолдолд та үйлчилгээний төвд хандах хэрэгтэй. Мөн ПИН кодоо солихыг хүсвэл заавал хуучин ПИН кодоо оруулдагыг анхаарна уу.


(2) Утас түгжих

Таны төхөөрөмжийг түгжих тохиргоог хийнэ. Кодоо солихын тулд хуучин оруулах ёстойг анхаарна уу.




7.6 Өгөгдлийн хэрэглэгдсэн хэмжээ

Нийт хэрэглэсэн өгөгдлийн хэмжээг харах болно.




7.7 Интернет(TCP/IP)

Интернэтэд холбогдоход нэмэлт тохиргоо шаардлагатай бол энэхүү цэсэнд хийх болно.



7.8 Мэдээлэл

Модемны мэдээлэл, программын хувилбарын талаар мэдээллийг харуулах цэс юм.



8. Интернет

8.1 Интернетэд холбогдох

(1) Үндсэн цэсэн дундаас интернет гэсэн цэсийг сонгоно. Энэхүү цэсэнд доорх дэлгэц гарч ирэх ба та Connect гэдэг товчлуурыг дарж интернетэд холбогдоно. Холбогдохдоо Connection тохиргоог хийсэн байх шаардлагатай.



8.2 Интернет салгах

- (1) Модемоо салгахдаа заавал компьютертээ интернэтээ салгасан байх ёстойг анхаарна уу.



9. Үзүүлэлт

Хүчдэл	5V/20mA(Sleep)/ 700mA(MAX.)
Гарах хүчдэл	0.2~0.3W
Хүлээж авах	869.04~893.97MHz
Илгээх	824.04~848.97MHz
Sensitivity	-104dBm(FER=0.5%)
Орчны темпратур	-20°C~60°C
Ажиллах темпратур	-30°C~90°C
CDMA 1xEV-DO, IS-95A/B/C	CDMA үзүүлэлтүүд
IS-637	Мессеж
IS-707	Өгөгдлийн үйлчилгээ
Ажиллах үйлдлийн систем : Windows 98 / ME / 2000 / XP / Vista	
Яриа хийх, Утасны жагсаалт, Мессеж, үйлчилгээний түүх	
Сүлжээний протокол : TCP/IP	